| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b> | 377,970,300.00        | 375,553,975.07 | 99.4 |

|             |  |                |                |       |
|-------------|--|----------------|----------------|-------|
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 377,970,300.00 | 375,553,975.07 | 99.4  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 377,670,300.00 | 375,253,975.07 | 99.4  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 285,036,300.00 | 283,755,566.00 | 99.6  |
| 210101      | Үндсэн цалин   | 190,266,300.00 | 189,677,026.00 | 99.7  |
| 210102      | Нэмэгдэл   | 64,270,000.00  | 63,857,393.00  | 99.4  |
| 210104      | Урамшуулал   | 30,500,000.00  | 30,221,147.00  | 99.1  |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 38,479,700.00  | 37,763,167.07  | 98.1  |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 27,078,400.00  | 26,361,867.07  | 97.4  |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 2,850,300.00   | 3,005,513.49   | 105.4 |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 2,280,300.00   | 2,125,086.51   | 93.2  |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 570,000.00     | 570,000.00     | 100.0 |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 5,700,700.00   | 5,700,700.00   | 100.0 |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 16,500,000.00  | 16,086,432.00  | 97.5  |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 3,500,000.00   | 2,869,592.00   | 82.0  |
| 210302      | Түлш, халаалт  | 11,000,000.00  | 11,055,340.00  | 100.5 |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 2,000,000.00   | 2,161,500.00   | 108.1 |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 8,296,200.00   | 8,294,960.00   | 100.0 |
| 210401      | Бичиг хэрэг  | 271,200.00     | 271,200.00     | 100.0 |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 5,500,000.00   | 5,498,760.00   | 100.0 |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 960,000.00     | 960,000.00     | 100.0 |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 314,700.00     | 314,700.00     | 100.0 |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,250,300.00   | 1,250,300.00   | 100.0 |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 11,371,100.00  | 11,368,350.00  | 100.0 |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 90,400.00      | 90,000.00      | 99.6  |
| 210502      | Хоол, хүнс   | 10,376,700.00  | 10,374,350.00  | 100.0 |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 904,000.00     | 904,000.00     | 100.0 |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 8,727,300.00   | 8,727,300.00   | 100.0 |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 4,500,000.00   | 4,500,000.00   | 100.0 |
| 210602      | Тавилга  | 1,500,000.00   | 1,500,000.00   | 100.0 |
| 210604      | Урсгал засвар  | 2,727,300.00   | 2,727,300.00   | 100.0 |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 226,000.00     | 226,000.00     | 100.0 |
| 210702      | Дотоод албан томилолт  | 226,000.00     | 226,000.00     | 100.0 |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 2,101,500.00   | 2,100,000.00   | 99.9  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,361,500.00   | 1,360,000.00   | 99.9  |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 540,000.00     | 540,000.00     | 100.0 |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 200,000.00     | 200,000.00     | 100.0 |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 6932200.00     | 6932200.00     | 100.0 |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 316,400.00     | 316,400.00     | 100.0 |

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |  |                |                |       |
|-------------|--|----------------|----------------|-------|
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх        | 6,615,800.00   | 6,615,800.00   | 100.0 |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                  | 300000.00      | 300000.00      | 100.0 |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>            | 300,000.00     | 300,000.00     | 100.0 |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 300,000.00     | 300,000.00     | 100.0 |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>    | 377,970,300.00 | 375,553,975.07 | 99.4  |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>           | 358,743,000.00 | 356,740,243.07 | 99.4  |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 358,743,000.00 | 356,740,243.07 | 99.4  |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>    | 19,227,300.00  | 18,813,732.00  | 97.8  |
| 132001      | Орон нутгийн төсвөөс                     | 19,227,300.00  | 18,813,732.00  | 97.8  |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                  | 25.00          | 25.00          | 100.0 |
| 620001      | Удирдах ажилтан                          | 01.00          | 01.00          | 100.0 |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан                        | 18.00          | 18.00          | 100.0 |
| 620003      | Үйлчлэх ажилтан                          | 06.00          | 06.00          | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Гүйцэтгэл  |
|------------|--|------------|
| I          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | 261,800.00 |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ  | 261,800.00 |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 261,800.00 |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал   | 261,800.00 |
| 210405     | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 261,800.00 |
| II         | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   | 261800.00  |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 261,800.00 |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 261,800.00 |
| IV         | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)   | 0.00       |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | 0.00       |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 0.00       |

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой, зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Д.Оюундаваа, аудиторын туслах П.Ундармаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Мядагмаа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 383.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27.6 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт    |
|---|-------------------|--------------------|-------------|
| Б   | 1                 | 2                  | 3=2-1       |
| Мөнгөн хөрөнгө  | 00                | 00                 | 00          |
| Авлага  | 00                | 0.08               | 0.08        |
| Урьдчилгаа  | 00                | 00                 | 00          |
| Бараа материал  | 93.4              | 109.7              | 16.3        |
| Үндсэн хөрөнгө  | 566.1             | 583.9              | 17.8        |
| <b>Нийт хөрөнгө</b>                                   | <b>659.5</b>      | <b>694.5</b>       | <b>35.0</b> |
| Өр төлбөр   | 0.00              | 0.00               | 0.00        |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/                   | 659.5             | 694.5              | 35.0        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө<br/>өмчийн дүн</b> | <b>659.5</b>      | <b>694.5</b>       | <b>35.0</b> |

Бараа материалын дансны үлдэгдэл 109.7 сая төгрөг болж 16.3 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байгаа нь дараах ажил гүйлгээ нөлөөлсөн. Үүнд

- Төсвийн хөрөнгөөр нийт 37.4 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийгдсэн.
- Боловсрол соёлын яамны хөрөнгө оруулалтаар 5.3 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай нийлүүлэгдсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 583.9 сая төгрөг болж 17.8 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байгаа нь дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгө 6.0 сая төгрөг.
- Боловсрол соёлын яамны хөрөнгө оруулалтаар 24.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж сургалтын хэрэгдлэгдэхүүн нийлүүлэгдсэн :
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 68 нэр төрлийн 54.5 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, 16.8 сая төгрөгөөр өртгийг шинэчлэн тогтоосон байна.
- Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн №18 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 4 нэр төрлийн 2.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан.
- Тайлант хугацаанд 29.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг тус тус нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолоор 469.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 дугаар тогтоолоор тодотгол хийж, нэг удаа зохицуулалт хийж, тус байгууллагын төсвийг 425.4 сая төгрөг болж 43.9 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар зохицуулалт хийгдэж төсвийн зарлага 378.2 сая төгрөг болж анхны батлагдсан төсвөөс 91.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол /71801/ хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 425.4 сая төгрөгийн төсөв баталснаас 406.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 19.2 сая төгрөг, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 358.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 19.2 сая төгрөг нийт 378.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд

375.6 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 2.4 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 375.6 сая төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь ковид-19 цар тахлын улмаас 190 хоног хичээллэхээс 101 хоног хичээллэснээр нормативт зардал, байр ашиглалт, үндсэн цалинтай холбоотой тогтмол зардал дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/40 тушаалаар ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалтаар нэмэлт төсвийн дансаар нийт 0.3 сая төгрөгийн орлого хүлээн авсан.

Нэмэлт төсвийн дансанд хүлээн авсан орлогын зарцуулалтын эрхийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журамд заасан баримтыг бүрдлийг ханган HT№1 маягтаар төрийн санд хүргүүлж эрх нээлгэж зориулалтын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан байна. Үүнд:

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторовын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэээллийг шалгахад 490.4 сая төгрөгийн 71 мэдээллийг ил тод байршуулахаас, 482.4 сая төгрөгийн 69 мэдээллийг ил тод байршуулж, 8.0 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллсэн байдлын хэрэгжилт 92.9 хувьтай байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.6 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 9.5 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 17.1 сая төгрөгийн 1 зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч, 1.0 сая төгрөгийн 1 акт тотоолоо.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 9.5 сая төгрөгийн 5 алдааг залруулсан. Үүнд:

1. Нийгмийн даатгалын цахим мэдээллийг, Нягтлан бодох бүртгэлийн цалин, шимтгэлтэй тулгахад нийгмийн даатгалын шимтгэлд 0.8 сая төгрөгийн илүү төлөлт хийгдсэн боловч бүртгэлд авлагаар тусгаагүй, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг бууруулж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.6.бүх зардал; 20.2.7.аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах гэсэн заалтуудад нийцэхгүй тул илүү төлсөн НДШ-ийг авлагаар залруулсан.
2. Хүүхдээ асарч буй Батсүрэн, Отгонням нарын 2 дугаар сарын ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг, үндсэн цалингийн зардалд бичилт хийж цалингийн зардлыг 0.1 сая төгрөгөөр өсгөсөн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх зарчимд нийцэхгүй тул залруулсан.
3. Жайка төслийн байгууллагаас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн автомакс 1 ш 30.0 мянган төгрөг, ариутгалын бодис 4 ш 43.6 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг орлогод аваагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5.бүх орлого; гэсэн заалтад нийцэхгүй тул орлого авч залруулсан.
4. Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар

тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад 490.4 сая төгрөгийн 71 мэдээллийг ил тод байршуулахаас, 482.0 сая төгрөгийн 68 мэдээллийг ил тод байршуулж, 8.0 сая төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй, байгаа нь 6.4.5.Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гэсэн заалтуудад нийцэхгүй тул аудитын хугацаанд мэдээлж залруулсан.

5. Эрхлэгч А.Дунгармаа нь 2021/3/15 өдрийн Б/08 тушаалаар улирлын үр дүнгийн урамшууллыг цалингийн 60%-р тооцож олгохоор өөртөө тушаал гаргаж бодож олгогдсон нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 11.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй байгаа нь “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын хугацаанд төлбөрийг барагдуулж ажилласан.

#### 4.2 Төлбөрийн акт

4.2 Үйлчилгээний 4 ажилтны баяр ёслол, илүү цагаар ажилласан цалин хөлсний тооцооллыг буруу хийж, 1.0 /нэг сая арван долоон мянга найман зуун дөчин долоо/ төгрөгийг илүү олгосон нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; заалтыг зөрчиж байгаа нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

#### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.Анхан шатны баримт е-баримтаар бүрэн нотлогдсон эсэх

- 1.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын 17.1 сая төгрөгийн гүйлгээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтад нийцэхгүй байгаа нь “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  - 1.2 Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- 1.1 Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр                  | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |     |               |     |                 |     |         |      |
|-----|--|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|------|
|     |  |                      |      | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |      |
|     |  | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн  |
| 1   | Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын хүүхдийн цэцэрлэг | 7                    | 27.6 | 5         | 9.5 | 1             | 1.0 | -               | -   | 1       | 17.1 |

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо:

АУДИТОР

Л.МАНДАХНАРАН Огноо: 5/21

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Д.ОЮУНДАВАА Огноо:

